

ТӨСӨЛ

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 232 дугаар зүйлийн 232.2, 268¹ дугаар зүйлийн 268¹.1.1 дэх заалт, 269¹ дүгээр зүйлийн 269¹.1.1 дэх заалт, 270¹ дугаар зүйлийн 270¹.1.4 дэх заалт, 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.1, 271¹.1.2, 271¹.1.17 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 00-ны өдрийн хуралдааны 00/00 дугаартай шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/79 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “ТИР Конвенцийг хэрэгжүүлэх, ТИР карней бүхий бараа, тээврийн хэрэгсэлд хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2, 3.3, 3.4, 3.12, 4.4, 4.10, 5.2 дах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

-3.2.Тээвэрлэгч Гаалийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан бичиг баримтаас гадна ТИР конвенцийн 4 дүгээр зүйлд заасан Зөвшөөрлийн гэрчилгээ болон ТИР карнейг гаалийн байгууллагад өгч, gaali.mn, ceps.gaali.mn-ээр нэвтэрч “Зорилго” хэсгээс Түр (ТИР Карнейтэй)-г сонгон TIR-EPD системээс холбогдох карнейн мэдээллийг татаж, улсын хилээр нэвтрэх хүсэлт илгээнэ.

-3.3.Дээрх хүсэлтэд хилийн гаалийн байгууллагын автотээврийн хэрэгслийн бүртгэл хариуцсан гаалийн улсын байцаагч CAIS системын Хяналт- Тээвэр (шинэ) хэсэгт оруулсан мэдээллийг үндэслэн хяналт тавина.

-3.4.Тээврийн хэрэгслийг шалгахгаар томилогдсон гаалийн улсын байцаагч ТИР конвенцийн 4 дүгээр зүйлд заасан Зөвшөөрлийн гэрчилгээ болон ТИР карней хүчинтэй эсэхийг TIR-EPD системийн мэдээлэлтэй тулган нягталж, тээврийн хэрэгсэлд шалгалт хийнэ. Шаардлагатай тохиолдолд гаалийн байгууллагаас ТИР карней бүхий барааг шалгана.

-3.12.Тээврийн хэрэгсэлд шалгалт хийсэн гаалийн улсын байцаагч бараа, тээврийн хэрэгслийн дагалдах бичиг баримтыг цахимаар хүлээн авсан мэдээлэлтэй тулган шалгаж, ТИР карнейн нүүр хуудаст үдэж тээвэрлэгчид шилжүүлнэ.

-4.4.Тээвэрлэгч Гаалийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан бичиг баримтаас гадна ТИР конвенцийн 4 дүгээр зүйлд заасан Зөвшөөрлийн гэрчилгээ болон ТИР карнейг гаалийн байгууллагад өгч, gaali.mn, ceps.gaali.mn-ээр нэвтэрч “Зорилго” хэсгээс Түр (ТИР Карнейтэй)-г сонгож улсын хилээр нэвтрэх хүсэлт илгээнэ.

-4.10.Эхний болон эцсийн бүрдүүлэлт хийсэн гаалийн байгууллагуудын ТИР карнейн бүртгэл, мэдээлэл хариуцсан гаалийн улсын байцаагч Хэлэлцээрийн 1-р хавсралтад заасан үзүүлэлтээр мэдээг гаргаж, эхний бүрдүүлэлт хийсэн гаалийн байгууллага CAIS системийн Хяналт-Тээвэр (шинэ)-ТИР цэс дэх мэдээллийг Олон улсын автотээврийн холбооны ТИР карнейн бүртгэлийн програмд үнэн зөв оруулах.

-5.2.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх ТИР карней бүхий бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр гаргах гаалийн байгууллагын автотээврийн хэрэгслийн

бүртгэл хариуцсан байцаагч CAIS системийн Тээвэр (шинэ) дэд програмаас ТИР цэсэнд тээврийн хэрэгслийн бүртгэлийн нотолгооны дугаарыг татан бүртгэж, гаалийн хяналтад оруулна.

2.Энэхүү журамд дор дурдсан найруулга бүхий 1.3, 7.7, 7.8 дахь заалтуудыг нэмсүгэй.

-1.3.Олон улсын авто тээврийн холбоо, гаалийн байгууллага болон тээвэрлэгч байгууллага хооронд ТИР карнейн мэдээллийг илгээх, хүлээн авах, хяналт тавихад TIR-EPD систем, эсхүл цахим ломбо бүхий хяналтын системийг ашиглана.

-7.7.Тээвэрлэгч нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, битүүмжлэлийг гаалийн хяналтад хамруулах зорилгоор энэ журмын 1.3-т заасан системд нэвтрэх эрхийг гаалийн байгууллагад гаргаж өгнө. Дээрх төрлийн системгүй тохиолдолд энэ журмын 7.8-д заасны дагуу хяналт тавих боломжоор хангана.

-7.8.Тээвэр зуучлагчаас цахим ломбо бүхий хяналтын системийг нэвтрүүлэх тохиолдолд гаалийн байгууллагын системд холбуулж, мэдээллийг бодит цагийн горимоор солилцон, гаалийн байгууллагаас хяналт тавьж ажиллах боломжийг бүрдүүлсэн байна.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, бүрдүүлэлтийн газар (Б.Даваасүрэн), Хуулийн хэлтэс (Ч.Тамираа), Шуурхай хяналтын төв (Ц.Хатанболд), Мэдээллийн технологийн газар (Б.Ганзориг) -т тус тус даалгасугай.

4.Энэ тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг харьяа гаалийн, хорооны дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

П.ДЭЛГЭРНАРАН